



SOLONGO EXIM LLC

**TEAM
BUILDS
POWER**

**TEAM
BUILDS
POWER**

ТАНИЛЦУУЛГА



SOLONGO
EXIM LLC

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, СБД 1-р хороо, энхтайвны өргөн
чөлөө 17, Зориг сангийн байр, 1 тоот
Утас: 99153637, 8805-2006

И-Мэйл: saruul@solongo-exim.com



PASSION FOR PARTS

АЛБАН ЁСНЫ ТҮНШ

ЯВАХ ЭД АНГИ

Төхөөрөмжийн явах эд анги гэдэг тодорхойлолтонд гинж, доод тавцан, дамар, өнхрүүлэг, хөтлөх араа, хөтлөгдөх араа гэх мэт олон сэлбэг бүтээгдэхүүн ордог. Дээр дурдсан нэр бүхий эд ангиуд нь зохион бүтээх, түүхий эд сонгох, үйлдвэрлэх үе шат дамжлагатайгаар нь концернийн салбар нэгж буюу үйлдвэрлэлийн нэгж хэсэг дээр бүтээгддэг. Үйлдвэрлэлийн явцад түүхийн эд, төмөр боловсруулалт, үйлдвэрлэлт эцсийн бүтээгдэхүүн гаргах, борлуулалтын өмнөх гэх мэт чанарын шалгалтуудаар баталгаажсаны эцэст хэрэглэгчдэд хүрдэг. Тус концерн нь орчин үеийн ололт инноваци ашиглан бүтээгдэхүүний чанарыг байнга шинэчилж ажилладаг. Тухайн нэгж бүтээгдэхүүн явц нь халааж хайлуулах, хэвэнд оруулах, цутгах, угсрах, будах гэсэн үндсэн үйлдвэрлэлийн чиглэлүүдээс бүрдэнэ. ITR концерны санал болгож буй бүтээгдэхүүн нь зах зээл дээр байгаа ижил төстэй бүтээгдэхүүнээс төрөл, тоо хэмжээ, нийлүүлэх барааны чанарын хувьд илүү өргөн сонголттой байдаг. Тухайн концерн энгийн ковш, бульдозерын сэлбэг нийлүүлэхээс гадна зам засварын тоног төхөөрөмжийн, өрөмдлөгийн төхөөрөмж, ойн аж ахуйн том төхөөрөмжүүдийн сэлбэг нийлүүлэх боломжтой. Өөрийн өндөр үр чадвартай мэргэжлийн техникчидийн тусламжтайгаар тусгай зориулалтын, болон олдох боломжгүй, үйлдвэрлэлт зогссон төхөөрөмж сэлбэгийг захиалгаар тохирох хэмжээний дагуу шинэчлэн үйлдвэрлэж өгөх боломжтой.



ЯВАХ ЭД АНГИ

TRACKONE нь тус концерны гинжит төхөөрөмжийн төлөвлөлт, техникийн боловсруулалт, судалгаа, үйлдвэрлэл хариуцсан салбар нэгж юм. Үйл ажиллагаа нь хэрэглэгч нарын шаардлага дээр тулгуурлан явагддаг. Бүтээгдэхүүний чанар болон хийц нь хүсэлт болон үйлчлүүлэгчийн инженер техникийн ажилчид бидний түнш байгууллагууд болох судалгаа шинжилгээний газрууд их сургуулийн эрдэмтдийн шинэ санаан дээр тулгуурлан шинэчлэгдэж бүтээгддэг. Аливаа бүтээгдэхүүн эцсийн хэрэглэгчийн гарт хүрэхээс өмнө төлөвлөлтөөс эхлэн үйлдвэрийн угсралт хүртэл дамжлага тус бүрийн чанарын нарийн хяналт шалгалтанд орж төслийн нийт хугацаанд зорилт болон үнийн уян хатан байдал, чанар, нийлүүлэх хугацааг тооцож үйлдвэрлэгддэг ба үйлдвэрлэлийн шат дамжлагыг тогтмол шалгаж, шинэчлэж, сайжруулдаг. Судалгаа шинжилгээний баг байнга шинэ зүйл туршиж бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх тал дээр ажилладаг.



ШҮД, ХУТГА

USCO концерны чухал хэсэг бол тоног төхөөрөмжийн шүд, хутганы боловсруулалт шинэчлэлийн хэсэг юм. Энэ нь сүүлийн үед их эрчимжэж концерны хамгийн шилдэг ололт болон их хөгжиж буй салбар юм. Энэхүү салбар нь бульдозер, ковш болон ачигчийн хуучин шанага хутганы ир, сэрээ солих, шинэчлэх, наслалтыг уртасгах зорилготой бий болсон. Энэхүү салбарт булангийн хамгаалалт, зам, булангийн зам, хатуулга төмөр хийц, шүдний бэхэлгээ, хутга гэдэг мэт олон төрлийн эд анги зохион бүтээж үйлдвэрлэдэг.



АЧИЛТЫН ЗАМ

Хөнгөн цагаан ачилтын зам нь бага оврын ковш шанагат экскаватор болон бусад төрлийн төхөөрөмжүүдийг түргэн ачиж буулгах зорилготой бүтээгдсэн. Эдгээр ачилтын зам нь чанарын ISO 9001 сертификатай бөгөөд уул уурхай, зам засвар, газар тариалан, энгийн нөхцөлд ашиглагдах бүтээгдэхүүн юм.



Өөрийн жин нь 14 хүртэл жинтэй бүхий л төхөөрөмжийг ачиж буулгах боломжтойгоор



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

ШАНАГА

USCO групп нь ухах, ачих шанаганы боломжит бүх хэлбэр загвараар үйлдвэрлэдэг. Энгийн загвараас хүчитгэсэн, хамгаалалттай гэх мэт хувилбар сонгох боломжтой.



ЦОХИЛТОТ ХОШУУ

ITR брендийн цохилтот хошуу нь өөрийн жин, цохилтын хүч зэргээс хамааран олон төрөл бий. Эдгээр цохилтот хошууг Италид бүтээж үйлдвэрлэдэг.

ITR брендийн цохилтот хошууг шинжлэх ухааны дэвшилтэт технологиор бүтээдэг бөгөөд өөрийн хийц үр бүтээлтэй ажиллах боломжоороодэлхийд тэргүүлэх бренд болсон. ITR брендийн цохилтот хошуу нь байгаль орчинд ээлтэй, дуу чимээ бага гаргадаг бөгөөд хот суурин газар уул уурхайд аль алинд ч өргөн хэрэглэх боломжтой.



СЭЛБЭГ

Сэлбэгийн үйлдвэрлэлийг 1990 оноос хойш эхлэн Модена дахь үйлдвэртэй байнга шинэчлэн үйлдвэрлэж ирсэн. Цаг хугацааны туршид үйлдвэр нь эцсийн хэрэглэгчийн хүсэл сонирхол болон шаардлагад нийцүүлж шинэчлэх нь энэхүү үйлдвэрийн гол зорилго юм. USCO группын техникийн хэлтэс үйлдвэрлэлийн хэлтэстэй хамтран чанарын өндөр түвшний сэлбэгийг үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр байнга анхааран ажиллаж байна. Сэлбэгийн үйлдвэрлэл нь хөдөлгүүрийн сэлбэг эд анги, хурдны хайрцаг болон хөтлөгчийн сэлбэг эд анги, явах эд ангийн сэлбэг болон элэгддэг сэлбэгийн өргөн сонголттойгоор зах зээлд нийлүүлдэг. USCO групп нь дэлхий даяар олон тооны үйлдвэрийн нэг болох ITR Messanica үйлдвэрээрээ дан ганц шүдэт арааны насосыг нэрт бренд болох CAT болон Komatsu 400 гаруй тусгай зориулалтын төхөөрөмжинд зориулж 60000 төрлөөр үйлдвэрлэдэг.



ХАЙМРАН ГИНЖ

Бага оврын явах эд анги болон хаймран гинж 2000 оны эхээр их эрэлт хэрэгцээтэй болсон. Олон жилийн турш хэрэглэгчийн зорилгод нийцүүлэн үйлдвэрлэх явцад туршлага хуримтлуулсан USCO групп нь энэ үйлдвэрлэлийн чиглэлд байж болох бүх төрлийн хаймран гинжийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж санал болгож байна. Судалгаа шинжилгээ хийх явцад байнгийн туршилт хийгдэж байсан ба ажил явагдсаны туршид болон хэрэглэгчийн санал гомдлын дагуу шинэчлэгдсээр одоогийн чанарын өндөр түвшинд хүрсэн бүтээгдэхүүн ITR брендийг бий болгосон байна.

Хаймран гинж бүтээх ажлын хүрээнд дотор төмөр эд ангиудын бүтэц болон тухайн гинжтэй харьцах эд ангиудын сайжруулах, шинээр бий болгох ажил давхар хийгдэж ирсэн.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

Зах зээл дээр шаардлагад нийцсэн бүтээгдэрүүн болон өөрийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэх зорилгоор USCO групп тогтмол шинэ бүтээгдэхүүн зохион бүтээдэг. Саяханаас USCO групп нь дараах 3 төрлийн барааг санал болгож эхэлсэн:

- Ачигч болон ковшны шанага
 - Ачигчийн зам
 - Цохилтот хошуу
- Шанага нь: хүчитгэсэн шанага нь ачигч болон ковш төхөөрөмжинд залгах боломжтой. Суваг ухах, хадат эрэг ухах болон бусад хэрэглэгчийн шаардлагад нийцэж хэрэглэгдэнэ. Ачигчийн замыг жижиг буюу дунд гарын 0,4-12 тонны төхөөрөмжийг ачиж тээвэрлэхэд зориулсан. ITR брендийн цохилтот хошуу нь хүчин чадал ихтэй, дэвшилтэт технологи ашигласнаас гадна байгаль орчинд ээлтэй дуу чимээ багатайгаараа онцлог.

ГИНЖИТ ЯВАХ ЭД АНГИЙН СЭЛБЭГ

USCO групп нь ITR брендийн гинжит төхөөрөмжийн явах эд ангийн сэлбэгийн үйлдвэрлэхдээ өөрийн түнш Их сургуулиудын эрдэмтэдтэй нягт хамтран ажиллаж орчин үеийн CAD систем ашиглан зохион бүтээж, төлөвлөж үйлдвэрт нэвтрүүлдэг. Түүхий эдийн сонголт, түүхий эдийн боловсруулалт, хатжилт зэрэг бүхий л дамжлагад чанарын хатуу хяналт тавьж эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгч ажилладаг.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЛБА


Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн алба нь Итали болон Өмнөд Солонгост байрлах бөгөөд Шинжлэх ухааны дэвшилтэт ололт, түүхий эдийн онцлог, технологийн аргачлал зэргийг хослуулан шинэчлэх сайжруулах судалгааны ажил хийдэг.

Судалгааны бүх ажлууд Итали дахь төв дээр нэгтгэгдэн загвар бүтээгдэж туршигдсаны эцэст үйлдвэрлэлд орж бүтээгдэхүүн шинэчлэгдэн гардаг.




ҮЙЛДВЭРЛЭЛ

Хэвэнд оруулах хэсэг нь 35.000 м2 талбайтай шинээр баригдсан үйлдвэрт 1.600-с 2.500 тонны пресс ашиглан хийгддэг. Үйлдвэрийн цутгах хэсэг нь 30.000 м2 талбайтай бөгөөд гадна агуулахын талбай нь 54.000 м2 юм. Жилийн хүчин чадал нь 10.000 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Олон улсын стандартад нийцэх бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэхийн тулд цутгах хэвэнд оруулах болон төмөр хатаах хэсгийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн байгаа.




ЧАНАРЫН БАТАЛГАА

Бүтээгдэхүүний чанар болон Codesign сайжруулах болон хянах зорилгоор Модена хотын Их Сургуулийн дэргэдэх Тоног төхөөрөмж үйлдвэрлэл ба бүтцийн судалгааны Дээд Сургууль, Регио Емиллиа Их Сургууль болон бусад Их Сургууль ба Лабораториудтай хамтран ажилладаг. Үйлдвэрлэлийн явц болон дараах үеийн чанарын хяналт туршилтыг хийх зорилгоор хэлтэс салбар нэгж бүр өөрийн туршилтын лаборатори газартай. Туршилтууд өөрийн бүтээсэн болон дэлхийд танигдсан төхөөрөмжүүд дээр олон улсын хэм хэмжээ стандартын дагуу явагддаг.




Шинж төрөл тодорхойлох


Гинжний төрөл тодорхойлоход дараах 3 ангилал бий:



ГИНЖНИЙ ӨРТӨН(мм)



ШҮДНИЙ ХООРОНДЫН ЗАЙ(мм)




ШҮДНИЙ ТОО

ШҮДНИЙ ЗАЙ: Хаймран гинжний үндсэн хэмжигдэхүүн нь шүд хоорондын зай юм. Шүд хоорондын зай гэдэг нь дараалсан 2 шүдний үзүүрээс үзүүр хүртэл зайг хэлнэ. Хоорондын зай ойр холоороо тухайн гинж нь 2 хуваагддаг: Хол шүдэт ба ойр шүдэт.

Хөтлөх дугуйны 2 дахь шүд болгонд хөтлөгддөг гинжийг бүрэн буюу хол шүдэт гинж гэнэ.


ХОЛ ШҮДЭТ




ОЙР ШҮДЭТ




ЭНГИЙН



ТӨМӨР ГИНЖ ОРЛУУЛАХ



ТӨМӨР ЦӨМГҮЙ



			GROBE (mm)							max. MASCHINENGEWICHT	GEWICHT DER KETTE
										kg	kg
150	72	A	65	46	39	23	23	21	500	0,51	
180	60	B	61	54	32	25	20	22	500	0,60	
180	72	A	70	51	38	24	29	30	700	0,69	
180	72K	C	64	53	40	21	22	20	700	0,91	
190	72	A	68	50	38	21	28	27	800	0,70	
200	72	A-B	76	56	40	23	28	26	1200	0,90	
200	72K	C	71	53	39	23	30	29	1200	1,09	
230	72	A	82	57	40	24	30	26	1400	1,23	
			82	57	40	24	30	26			



БАГА ОВРЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ХАЙМРАН ГИНЖ

Бидний санал болгож буй ITR маркийн хаймран гинж нь орчин үеийн технологиор мэргэжлийн өндөр түвшний зохион бүтээгчдийн ололтыг ашиглан бүтээгдсэн бөгөөд элэгдэл багатай, бүтээмж өндөртэй ажиллах дээд зэргийн түүхий эд ашиглан үйлдвэрлэгдсэн болно. Тус хаймран гинж нь дэлхий даяар олон уурхай дээр туршигдаж танигдсан таны ажлыг удаан хугацааны турш саадгүй биелүүлнэ.


Манай компани нь бага оврын шанагат экскаватор болон ковш төхөөрөмжийн явах эд анги, гинж чангалагч, хөтлөгч дугуй, дамар болон угсралтын сэлбэг угсралтын багаж зэргийг санал болгож байна.




- Хэвэнд оруулсан төмөр цөм
- Уян налархай их бие
- Сэв урагдалтанд тэсвэртэй

- Гадаргуу дээр бага даралт үзүүлдэг
- Төмөр гинжнээс хөнгөн
- Дуу чимээ багатай, гадаргуутай харьцах нь их


ЭНГИЙН ГИНЖ



ТӨМӨР ГИНЖ ОРЛУУЛАХ



ТӨМӨР ЦӨМГҮЙ



ЭНГИЙН ГИНЖ

Энэхүү гинж нь зөвхөн хаймран гинж ашиглах зориулалттай төхөөрөмжинд ашиглагдана. Энэхүү төхөөрөмжийн хөтлөгч гинжний төмөр чиглүүлэгчтэй харьцах ба зөвхөн гинж мултрахаас хамгаалагдсан байдаг. Энэхүү төхөөрөмжүүд төмөр гинж ашиглах боломжгүй байдаг.

ТӨМӨР ГИНЖНИЙ ОРОНД ТАВИГДАХ

Энэхүү гинж нь төмөр гинж ашиглах зориулалттай төхөөрөмжинд хаймран гинж ашиглах шаардлага гарсан тохиолдолд ашиглах боломжтой. Энэ нь төмөр гинжний адил ашиглагдана.

ТӨМӨР ЦӨМГҮЙ ГИНЖ (NMC)

Энэхүү төрлийн хаймран гинж нь хаймар болон хүчитгэсэн төмөр утасны нийлбэр юм. Төмөр цөмгүй хаймран гинж нь төмөр цөмгүй учраас хөнгөн уян байдаг. Өргөн учир харьцаж буй гадаргууд ажлын даралт бага үзүүлдэгээрээ гэмтээх гэх мэт сөрөг үр дагавар багатай.

ЧИЧИРГЭЭНИЙ ЭСРЭГ ХАЙМРАН ГИНЖ (AV)

Чичиргээний эсрэг хаймран гинж нь өөрийн онцлог хөтлөх төмөр цөмийн тусламжтайгаар ажлын идэвхи хурдыг сааруулахгүйгээр өөрийн жин болон чичиргээг багасгадаг. Энэхүү төрлийн гинжний хөтлөх дамар нь гадаргуугаас үл хамаарах шулуун ажиллагаатай тул чичиргээг хамгийн бага түвшинд мэдэрдэг.

ЯВАХ ЭД АНГИЙН ГИНЖ БОЛОН ГАН ХИЙЦИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

ITR-явах эд ангийн гинж нь (TLAs) төрөл бүрийн загвар хийцтэй болон ашиглах төхөөрөмжийн төрөл ба ашиглагдах нөхцөл байдлын өргөн сонголттой үйлдвэрлэгддэг:

ЖИЙРЭГҮЙ (ХУУРАЙ ГИНЖ)



ГАН ЖИЙРЭГ (ТОСОЛГООТой)

ITR- гинжний үеүүд нь BORON гангаар хэвлэгдсэн. BORON ган нь элэгдэл бага гардаг гинжний үе томрох тусам хатуулаг нь Rockwell C50 гүн нь 8-12 мм байдаг.

ПОЛИРЕТАН ЖИЙРЭГ (ТОСОЛГООТой)

Бульдозерын тосолгоотой гинж нь Master Split- төрлийн үетэй байдаг. Үйлдвэрлэл нь USCO группын патентлагдсан аргачлалаар явагддаг.

ГИНЖИТ ЯВАХ ЭД АНГИ (ЖИЙРЭГТЭЙ, ТОСОЛГООТой)



Элэгдэлд тэсвэртэй хатуулагтай эд ангитай харьцаж байгаа холбох пальц үйлдвэрлэхэд тухайн түүхий эд боловсруулалтыг шаардлагад нийцүүлэх үүднээс материалын гадаргууг шатаах ба индукцийн аргаар хат суулгах хосолмол арга хэрэглэдэг.

Тухайн пальцны цөм нь гүлзайхгүй хатуу байхаас гадна өөр дээр ирж буй их ачаалал даахаас гадна гадаргуугаараа элэгдэлд тэсвэртэйгээр үйлдвэрлэгддэг.




Тосолгооны зориулалттай бульдозерын болон полиретан жийргэвчтэй гинж нь бүх улирлын жийрэгтэй байх бөгөөд ашиглагдах газрын онцлогоос хамаарч тусгайлан үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүн юм. Хүнд даацын машин механизмд ажиллагаа нь хэвийн явуулах зориулалтаар тусгайлан шинэ жийрэг бүтээгдсэн.

Жийрэгний хэлбэр болон үйлдвэрлэхэд ашиглагдаж байгаа түүхий эдийн орц найрлага, сонголтоос хамаарч тосолгооны материалыг гадагш нэвтрүүлэхгүй шаардлагатай тосолгоо хангагддаг.

ITR брендийн гинж нь бага оврын ковш экскаватороос том оврын уул уурхайн тоног төхөөрөмж хүртэл хэрэглэгдэх олон төрлийн бүтээгдэхүүн юм.



KOMATSU® PC20
(Гинжний үе 101 мм)-эс



CATERPILLAR® DI 1 T
(Гинжний үе 317 мм) хүртэл

ITR гинжний хавтангийн сонголт нь хамгийн ихээр хэрэглэгддэг хавтангуудын загвараар үйлдвэрлэгдэж байгаа.



нэг, хоёр, гурван босоо ханатай гинжний хавтан стандарт болон хүнд даацын гинжний хавтан тусгай гинжний хавтан

ЯВАХ БОЛОН ДААЦЫН ДАМАР

ITR брендийн бульдозер шанагат экскаваторын явах болон даацын дамар нь гадаргуйн болон цаг огаарын хүнд нөхцөлд ашиглагдахаар зориулан үйлдвэрлэгдсэн болно. USCO групп нь дэлхийд танигдсан ихээр ашиглагддаг бүхий л брендийн төхөөрөмжийн дамрыг үйлдвэрлэж санал болгодог. ITR брендийн дамар нь гангийн BORON төрлийн түүхий материал ашиглан дээд зэргийн чанартай цутгамал болон хэвэнд оруулсан бүтээгдэхүүн юм.




Дээд зэргийн төмрийн хатуулаг болон үйлдвэрийн орчин үеийн технологиор сэлбэгийн нарийвчилсан хэмжээг чанарын өндөр түвшинд гаргадаг. Сэлбэгийн үйлдвэрийн угсралт болон тосолгооны өндөр хяналттай тул сэлбэгийн насжилт болон үр ашигтай хэрэглээнд эерэгээр нөлөөлдөг. Санал болгож буй дамарны сонголт нь жижиг оврын ковшноос том уул уурхайн тоног төхөөрөмж хүртэлх бүхий л загвар хэмжээгээр нийлүүлэх боломжтой.

1,4 тонны KOMATSU® PC05
төхөөрөмжөөс



HITACHI® EX2500
248 тонны төхөөрөмж хүртэл



ЯВАХ БОЛОН ДААЦЫН ДАМАР

ITR брендийн цутгамал хөтлөх дугуйг орчин үеийн бүрэн автомат төхөөрөмжөөр дурын хэлбэр дүрс хэмжээгээр үйлдвэрлэж байна. Тухайн бүтээгдэхүүний чанар болон ажлын ачаалал дааж удаан эдлэхийн тулд гангийн өндөр агууламжтай түүхий эдээр цутгаж зориулалтын дагуу хатжуулдаг. ITR брендийн цутгамал хөтлөх дугуй нь үйлдвэр дээрээ бүрэн автомат төхөөрөмжөөр тослогдон тусгай зориулалтын шинэ үеийн холхивч жийргээр тоноглогдсон байдаг.




ITR брендийн цутгамал хөтлөх дугуй дараах төрлөөр үйлдвэрлэгддэг:

- Хөтлөх дугуй
- Холхивчтой эсвэл холхивч гол төмөртэй хөтлөх дугуй
- Чиглүүлэгч замтай хөтлөгч дугуй
- Сэрээтэй хөтлөгч дугуй
- Чангалагчтай хөтлөгч дугуй

Санал болгож буй хөтлөх дугуйны сонголт нь жижиг оврын ковшноос том уул уурхайн тоног төхөөрөмж хүртэл бүх загвар хэмжээгээр нийлүүлэх боломжтой.

KUBOTA® K008
(0, 9 тонны төхөөрөмжийн жинтэй)-ээс


KOMATSU® D475 A5
(101 тонны төхөөрөмжийн жинтэй) хүртэл



Шүд, үзүүр, шүдний бэхэлгээ, хамгаалалт зэргийг олон янзаар үйлдвэрлэдэг бөгөөд ямарч нөхцөлд угсрах, солих нөхөх боломжтой. Байгаль цаг уурын бүх нөхцөлд тохиромжтой.




Хутга хажуугийн болон булангийн хамгаалалтуудыг ашиглагдаж болох төхөөрөмжийн ихэнхэд нь зориулж үйлдвэрлэж байна. Эдгээр хутга болон шүд хамгаалалтуудыг сайжруулсан, хат сайтай гангаар үйлдвэрлэдэг.





ШИНЭЧЛЭЛ

Бүтээгдэхүүний чанар болон үйлчилгээний хүрээгээ байнгын нэмэх зорилгоор USCO групп жилээс жилд шинэчлэлийн ажил дээр хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж ажилладаг.




ШҮД БА ХУТГА

ITR брендийн шүд ба хутганы элэгдэл бага урт удаан ажиллагааны нууц нь зохион бүтээх, загвар, ашиглагдаж буй түүхий эд материалын түүвэр болон үйлдвэрлэх явц юм. Эдгээр шүд, хутганы чанар нь орчин үеийн дэвшилтэт технологи, сайн чанарын түүхий эд, өндөр мэргэжлийн техникийн ажилчдын үр авьяас шингэсэн хатжуулалтын сонгомол аргаар бүтээгддэг.



Зах зээлийн эрэлт хэрэгцээ, захиалагч нарын шаардлагын дагуу тусгайлан ITR бренд бүтээгдсэн болно. Зарим эд ангиудыг зөвхөн ITR брендээс олох боломжтой.



ITR брендийн шүд хутганууд олон төрлийн түрэгч, тэгшлэгч төхөөрөмжүүд дээр ашиглагдах боломжтой. Үүнээс гадна хутга шүдэнд хийгдэх хатуулагтай хамгаалалтуудыг бас санал болгодог. Энэ нь шүд хутгыг элэгдлээс хамгаалж ашиглагдах насыг уртасгадаг. Хутганы ир хамгаалахаас гадна хажуугийн босоо хамгаалалт, булангийн хамгаалалт гэх мэт өргөн сонголттой.



ГИНЖНИЙ ХӨТЛӨХ АРАА БА ЭД АНГИ

ITR брендийн гинжний хөтлөх араа ба эд ангийн сонголт нь жижиг оврын ковшноос том уул уурхайн тоног төхөөрөмж хүртэл бүх загвар хэмжээгээр нийлүүлэх боломжтой. Эдгээр сэлбэгийг цутгаж, хэвэнд оруулан хэвлэж үйлдвэрлэдэг.

Эд ангиудын үйлдвэрлэл нь хэвэнд оруулж автомат төхөөрөмжөөр нугалаа нүх зэргийг оруулан шатааж хатжуулдаг. Эдгээр эд ангиуд ихэвчлэн бульдозерт ашиглагддаг.



Цутгамал эд ангийг бүрэн автомат төхөөрөмжөөр цутгаж зориулалтын дагуу хатжуулдаг.




ITR брендийн гинжний хөтлөх араа ба эд ангийн сонголт нь жижиг оврын ковшноос том уул уурхайн тоног төхөөрөмж хүртэл бүх загвар хэмжээгээр нийлүүлэх боломжтой..

JCB® 8008

(0,95 тонны төхөөрөмжийн жинтэй)-ээс

KOMATSU® PC1250

(101 тонны төхөөрөмжийн жинтэй) хүртэл



ГИНЖНИЙ ХӨТЛӨХ АРАА БА ЭД АНГИ

ITR брендийн гинжний эд анги болон сэлбэгүүд нь гадуур түгээмэл ашиглагдаж буй төхөөрөмжинд таарч тохирох загвар хэмжээгээр үйлдвэрлэгддэг. Үүнд энгийн бульдозерээс гадна зам засвар, хөдөө аж ахуйн техник хэрэгсэл, уул уурхайн тоног төхөөрөмж зэрэг багтана.

Үйлдвэрлэлийн уян хатан байдал болон инженер техникийн ажилчдын өндөр оюун ухаан боловсрол, зохион бүтээх, төлөвлөгөө, үйлдвэрлэлийн хүчин чадал нь хэрэглэгчийн хүсэл захиалгын дагуу тусгай зориулалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.

ГИНЖИТ ТӨХӨӨРӨМЖ

БАГА ОВРЫН БУЛЬДОЗЕР, КОВШ

ОЙН АЖ АХУЙН ТӨХӨӨРӨМЖ

ГИНЖИТ КОВШ

ТӨМӨР БАЗАГЧ ТӨХӨӨРӨМЖ
MATERIALUMSCHLAG-
BAGGER

КРАН
KRAN



ХООЛОЙ УТГАГЧ
ROHRLEGER

КОМПСТЫН ТӨХӨӨРӨМЖ
KOMPOSTIERUNG

АСФАЛТ ХУУЛАГЧ
KALTRASE

ЧУЛУУНЫ БУТЛУУР
BRECHANIAGE



СЭЛБЭГ

CATERPILLAR® болон Komatsu® брендийн ихэнх төрлийн сэлбэгийг манай үйлдвэрийн агуулахаас захиалах боломжтой. Сүүлийн 40 жилийн захиалагч байгууллагын түүхийг эргүүлэн харахад зах зээлийн судалгаа болон худалдан авалт тогтмол өсөлттэй харагдаж байна. ITR Meccanica брендийн насосны эд анги болон хөдөлгүүрийн эд ангийн үйлдвэрлэлээр сүүлийн үед дэлхийд тэргүүлж байна.

COOLING SYSTEM FANS, HOSES, IMPELLERS, U.L., FILTERS, RADIATOR CORES, THERMOSTATS, WATER PUMPS, ELECTRICAL PARTS, ALTERNATORS, ALARMS & BORNERS, BRUSHES, ELECTRICAL TERMINALS, FUSES, GAUGES, LOW PLUGS, GOVERNOR CONTROL MOTORS, LIGHTS, HOUSING METERS, STARTER MOTORS, SWITCHES, ENGINE PARTS, CAMSHAFTS, ARTRIDGES, CHAMBERS, COMPRESSORS, CONNECTING RODS, CRANKSHAFTS, CYLINDER HEADS, ENGINE BEARINGS, ENGINE BLOCKS, ENGINE FERRULES, FUEL INJECTION SYSTEM, GASKET KITS, HEAT SHIELDS, UFTERS, LINERS, MANFOLDS, 14.7MERS, ANS, ASTON ANS, ASTON HINGS, ASTONS, RING GROUPS, ISOTATORS, SEALS, TURBOCHARGERS, AIR FILTERS, FUEL FILTERS, OIL FILTERS, STRAINERS, FRAME PARTS, BALUS, BEARING SLEEVES, BECY, GUIDE, BOGIE JOINTS, BOGIE MINOR, CAPS, CONNECTORS, EQUALIZE BARS, GUARDS, INSERT-PLATE, PIN PIVOTS, PROTECTIONS, RETAINERS, SHAFT PIVOTS, STRIPS, TRUNNIONS, HARDWARE PARTS, BOHS, BONNETS, DCIM, LIFTING EYEBOLTS, LOCK NUTS, NUTS, PINS, RIVETS, SNAP RINGS, WASHERS, HYDRAULIC PARTS, CARTRIDGES, CYLINDER GROUPS, UNDER KITS, HEAD BEARINGS, HOSES, ASTONS, PUMPS, REPAIR KITS, RODS, VALVES, VICKERS PUMP'S, PUMPS, ENGINE OIL PUMPS, LEL, PUMPS, HYDRAULIC GEAR PUMPS, ASTON PUMPS, S, PUMPS, TRANSMISSION PUMPS, TRANSMISSION PARTS, AXLES, CAG, CARRIERS, COUPLINGS, DIFFERENTIAL GEARS, RANGES, FRC, JSCS, GEARS, HUBS, NEEDLE, S, ANIONS, PLANETARY GEAR, IMPELLERS, TORQUE C, S, YOKES, OTHERS & V, HANHOLES, MIRRORS, SEATS, STEP, IMPEERS.



ITR брендийн гол давуу тал нь үйлдвэрийн орчин, агуулах, зохион бүтээх тасаг, тээвэрлэлтийн өмнөх үеийн гэх мэт боломжит бүх дамжлагуудад тогтмол давхар чанарын шалгалтаар ордогт оршино. ITR компани нь түүхийн эдийн чанарын үзүүлэлтийг үйлдвэрт ирэхээс өмнө нарийн шалгах шаардлага тавьж ажилладаг. Иймээс түүхий эд нийлүүлэгч байгууллагад шаардлага тавихаас гадна өөрсдийн мэргэжилтнүүд нийлүүлэгчийн агуулахад хамтын шалгалт явуулсны дараа бараа татах шийдвэр гаргадаг. Ингэснээр үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт байнгын ижил түвшинд байх боломж бүрддэг.



Түүхийн эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох хайлуулах, цутгах, хэвэнд оруулах, хатжуулах, угсрах гэх мэт нарийн ажилбарыг хариуцан хийдэг мэргэжилтнүүдийн өндөр ур чадвар мэдлэг боловсрол нь чанарыг бүтээдэг. ITR групп компанийн томоохон хэсэг нь ITR Meccanica юм. Энэ хэсгийг 60-аад оны үед үүсгэн байгуулагдсан бөгөөд 1970 оноос хойш АМК болон OEM эд анги дээрээ түлхүү судалгаа шинжилгээг хийж үйлдвэрлэлжирсэн арвин туршлагатай нэгж хэсэг юм. Модена дахь үйлдвэр нь нийт 12.000 м2 талбайтай үйлдвэр бөгөөд үүнээс 7.000 м2 нь битүү үйлдвэрийн хэсэг юм. Энэ үйлдвэр нь ITR Meccanica-ийн бүтээгдэхүүн болон ITR насос болон хөдөлгүүрийн эд анги зохион бүтээж туршилт хийн үйлдвэрлэх гол үүрэгтэй. Нарийн мэргэжлийн ажиллах хүч болон орчин үеийн тоног төхөөрөмж ашигласнаар ITR Meccanica нь их олон төрлийн сэлбэг эд анги үйлдвэрлэдэг. ITR Meccanica нь жилдээ 60.000 насос үйлдвэрийн шугамаараа гаргадаг зөвхөн Caterpillar® ба Komatsu® төхөөрөмжинд ашиглагдах 400 төрлийн насосыг үйлдвэрлэдэг.

